


ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ



2016 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР. 2016

НЭГ. АМЬДРАЛЫН ТУХАЙ ТОО БАРИМТУУД

Оршил

Яагаад ИЗНН-ын Мөрийн хөтөлбөрийг бид “АМЬДРАЛ” гэж нэрлэсэн бэ?

Яагаад энэ хэсэг макро эдийн засгийн, тэр болгон та ~~бид~~ сонирхоод байдаггүй ДНБ, улсын төсвийн орлого, зарлага мөнгөний ~~нийлүүлэлт~~ гэх мэт үзүүлэлтүүдээр биш, харин иргэн Таны амьдрах орчин, Таны эрүүл мэнд, боловсрол, Таны хоол хүнс, Таны амьдардаг хот, аймаг орон нутгийн байдал гэх мэт үзүүлэлтээр эхэлж байна?

Яагаад гэвэл эдгээр нь шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны тоо, баримтууд бөгөөд цаашид хэрхэх талаар дүгнэлт, бодлого арга замыг тодорхойлох үндэс болж өгдөг.

Яагаад гэвэл иргэн Та болон Таны үр хүүхдийн эвдрээгүй, сүйтгэгдээгүй байгаль орчинд, эрүүл сайхан амьдрах жам ёсны эрхийг ДНБ, эсвэл хичнээн сая тонн нүүрс, зэс, алт гэх мэт хуурай үзүүлэлтээр хангахгүй юм.

Яагаад гэвэл Таны болон Танай гэр бүлийн сайхан амьдрал нь баг, сум хороод, аймаг, хот, улмаар улс, үндэстний хөгжлийн суурь нь юм.

Тийм ч учраас ИЗНН Таны амьдралын, Таны амьдралд шууд хамааралтай тоо баримтууд дээр тулгуурлан “АМЬДРАЛ” мөрийн хөтөлбөрийн гол үндэслэл, нотолгоо болгож байгаа бөгөөд энэ нь улс төрийн бусад намуудын бодлогын бичиг баримтаас ялгарах онцлог болж өгч байгаа юм.

Тийм ч учраас ИЗНН-ын бодит амьдрал дээр суурилсан Мөрийн хөтөлбөр нь “Иргэдээрээ овоглосон, Иргэдийн төлөө, Иргэд хэрэгжүүлэх Мөрийн хөтөлбөр хэмээн нэрлэгдэж байгаа юм.

Тийм учраас ИЗНН 2012 оны УИХ-ын сонгуулийн “Амьдрал” мөрийн хөтөлбөрөө дахин шинэчилж, сонгогч Таньд өргөн барьж байна.

1.1. Эдийн засгийн тэгш бус хуваарлалт

- Сүүлийн арван жилд манай улсын ДНБ арав дахин өссөн ч энэ өсөлт цөөн хэдэн гэр бүлийг улам баяжуулж, жирийн иргэдэд наалдсангүй. Нийгмийн тэгш бус байдал газар авч, баян ядуугийн зааг ялгаа улам холдлоо.

- Нийгмийн олонх эдийн засгийн шийдвэр гаргах эрхээр хангагдах, эдийн засагт оролцоотой (өмчлөл) байх, баялгийн хуваарилалт илүү тэгш, хүртээмжтэй байх, эдийн засгийн эрх мэдлийн төвлөрөл аль болох бага байлгах төрийн бодлого алга байна.
- Баялгийн хуваарилалтыг илүү хүртээмжтэй, олон нийтийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэхэд маш чухал үүрэгтэй хөрөнгийн зах зээл хөлд орохгүй “нялх” хэвээр байна.
- 2016 оны эхний 3 сарын байдлаар төсвийн орлого 1.1 их наяд, зардал 1.7 их наяд, зөрүү нь 616 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.
- Хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ мөн өмнөх онтой харьцуулахад 1.7 хувиар өсчээ. Үүнд: Боловсролын үйлчилгээ 23.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлэг 3.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 5.6 хувиар өссөн байна.
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 11.8 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 443.9 тэрбум төгрөгөөр /3.6 хувь/ өсчээ.
- Татварын орлого 11 хувиар буурчээ.
- 2015 оны ажиллах хүчний судалгаагаар улсын хэмжээнд ажилгүй иргэд 96.5 мянга байсан аж. Бүртгэлтэй ажил хайгч 48.8 мянгад хүрч тэдний 58 хувь нь /18.4 мянга/ эмэгтэйчүүд байна.

1.2. Байгаль орчны доройтол ба хүний хөгжил

- Байгаль орчны доройтолд орсон газар нутагт амьдарч буй хүн амын эзлэх хувийн жингээр Монгол Улс Азид тэргүүлж байна. Ялангуяа Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Хөвсгөл аймагт газрын доройтол 60%-д хүрч, маш хурдацтай тэлж байна.
- Нэг хүнд ноогдох ашиглаж болохуйц усны нөөц Дорнод, Хэнтий, Орхон, Сүхбаатар, Өмнөговь зэрэг 7 аймгийн нутагт олон улсын стандарт хэмжээнээс доогуур байна.
- Хөдөөд нийт өрхийн 41% нь ариун цэвэр, эрүүл ахуйн хувьд баталгаагүй усны эх үүсвэр ашиглаж байгаагаас хүн ам эрүүл мэндийн эрсдэлд өртөн, уснаас шалтгаалсан өвчлөл нэмэгдэж байна.

МОНГОЛ
ҮНДСНИЙ АУДИТОРИЙН
УХААНЫ АУДИТОРЫН

УХАОД

№ 2

20 . 08 . 04

- Ойн сан жил тутам ойн талбайн 5%-иар доройтож байна. Ялангуяа Орхон, Дорнод, Дархан-Уул, Архангай, Баян-Өлгий аймагт энэ үзүүлэлт өндөр байна.
- Ядуурлын түвшин 2010 онд 39.3% байсан бол 2016 онд нэмэгдэв.

1.3. Хотуудын эмзэг байдал

**УЛСЫН
АТЫН ГАЗАР**

22

- 2000 онд хүн амын 56.3% нь хотод амьдарч байсан бол 2016 онд энэ тоо 68 %-д хүрэв.
- УБ хотын 1 хүнд ноогдох усны нөөц 962 м3, хэрэглээний усны хэмжээ 135 м3 байгаа бөгөөд ДЭМБ-ын судалгаагаар УБ хотын ундралын усны эх үүсвэрийн 67% нь ахуйн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй, эрүүл ахуйн шаардлага хангадаггүй байна.
- Туул голын дээд эхийн экосистем алдагдаж, хамгаалалтын онц нөхцөл байдал үүсэв.
- 2016 оны байдлаар УБ хотын нийт өрхийн дөнгөж 41% нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай нөхцөлд амьдарч байна.
- Хөдөөгийн өрхийн дөнгөж 35.8% нь төвийн эрчим хүчиний үйлчилгээ авч байна.
- Улсын хэмжээнд эрэгтэйчүүдийн 11%, эмэгтэйчүүдийн 13% нь архаг хууч өвчтэй, экологийн доройтлоос болсон өвчлөлийн хэмжээ эрс нэмэгдэж байна.
- 10 мянган хүнд ноогдох амьсгалын замын өвчлөлийн тохиолдол агаар дахь хүхэрлэг хий (CO2), азотын давхар исэл (NO2) болон тоосжилт (PM10) зэрэгтэй шууд холбоотой ба CO2-ын гол эх үүсвэр нь автомашины угаар, дутуу шаталт бүхий нүүрс юм.
- Цахилгаан станцаас гарч буй 4 сая орчим тн дэгдэмхий үнс нь маш нарийн ширхэгтэй тоосонцорыг нэмэгдүүлж, радио идэвхит бодис, хортой хүнд металлуудыг өөртөө агуулж байна.

1.4. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлөв

- Ойрын 20 жилд (2011-2030) агаарын жилийн дундаж температур -0.8 -1°C хэмээр нэмэгдэнэ.
- Ойрын хугацаанд өвлийн улиралд агаарын дундаж температур 0.2-0.7 хэмээр, дунд хугацаанд 1.6-2.3 хэмээр нэмэгдэнэ.
- Жилийн дундаж хур тунадасын хэмжээ ойрын хугацаанд бага зэрэг буюу 2-3%-иар, дунд хугацаанд 9%-иар нэмэгдэнэ. Энэ нь голцуу өвлийн улиралд тохиолдоно.

1.4.1. Эдийн засагт үзүүлэх нөлөө

- Бэлчээрийн гарц багасч байна. Бэлчээрийн нийт биомасс буурах хандлагатай.
- Усны нөөцийн бүтэц өөрчлөгдөж байна. Энэ нь хүнсний аюулгүй байдалд эрсдэл авчирч байна.
- Усны эх үүсвэрүүд хорогдоно.

1.4.2. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

- Одоогийн байдлаар нийт нас барагтын 2%-ийг халдварт болон паразитын гаралтай өвчин эзэлж байгаа ба энэ тоо цаашид өсөх хандлагатай.
- Зүрх судас, элэг, ходоод, чихрийн шижин зэрэг өвчнөөр өвчлөгсдийн тоо нас залуужих, өсөх хандлагатай байна.
- Монголын нүүдлийн соёл иргэншлийн язгуур өвд аюул нүүрлэж болзошгүй байна.

1.4.3. Биологийн төрөл зүйлийн хомдол

- 2030 он гэхэд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 30%-ийг хамгаалалтад авах үүрэг авсан ч энэ цаг хугацааг 2016 он болгож наашлуулах зайлшгүй байдал үүсч байна.
- “Уур амьсгалын дүрвэгсэд” – (climate refugee) гэсэн нэр Монгол Улсад бодит байдал болж эхлэв. Малчид үүнд хамгийн түрүүнд өртөж эхлээд байна.

1.4.4. Хүлэмжийн хийн ялгарал

- Хүлэмжийн хийн нийт ялгаруулалт 2006 онд 18868 гр-д хүрч, Монгол улс 185 орноос 96-р байрыг эзэлжээ. Улаанбаатар хотын нэг хүнд 13.5 тонн CO₂ ялгаруулалт ногдож байна.
- Монгол Улсын ДНБ-ын нэг ам.долларт ногдох CO₂ ялгаруулалтын түвшин дэлхийн нүүрс олборлогч томоохон 10 орноос хамгийн их нь байна. “Уур амьсгалын мэдрэмж”-тэй хөгжлийн хэрэгцээ
- Уур амьсгалын өөрчлөлт Монгол улсын эмзэг байдлын үндсэн шалтгаан болоод байна. Одоо л арга хэмжээ авахгүй бол оройтох аюул бодитой нүүрлэжээ.
- Баруун ба хойт зүгийн нутгийн зарим хэсэг, Хангай, Хэнтийн нуруу, томоохон голын сав газарт нутагладаг иргэдэд хур тундас нэмэгдэх, үер усны аюулд дасан зохицоход, харин.govийн болон зүүн өмнө зүгийн нутгийн иргэдэд усны хомдол, хуурайшилтанд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх талаар төрийн бодлого онц шаардлагатай болж байна.

МОНГОЛ У
ҮНДЭСНИЙ АУДИ

УХА0121

№ 78

20.16 он 04 сар

- Малчдын дунд баян, ядуугийн ялгаа нэмэгдэж, дундаж амьжиргаатай малчдын тоог нэмэгдүүлэх талаар төрийн бодлого үүгүйлэгдэж байна.
- Ойн доройтлыг онцгой анхааралд авах шаардлагатай боллоо. Улсын хэмжээнд ойн нөөц жилд дунджаар 5% доройтно гэвэл нийт ой устаж үгүй болоход 20 жил л шаардагдана. Архангай 10 жил, Баян-Өлгий 15 жил, Хөвсгөл аймаг 30 жилийн дараа ойгүй болохоор байна. ~~СЫН НИН ГАЗАР~~
- Уул уурхайд химийн аюултай бодис ашиглаж байгаагас нелөөлөл нь ноцтой болох магадлал өндөр байна. Албан бус уул уурхайд 2011 онд 70 мянга орчим хүн ажиллаж байна. Эмнэсти Интернэшнлийн судалгаагаар мөнгөн ус, цианит натрийг 9 аймгийн 20 гаруй суманд их хэмжээгээр ашиглаж, орон нутгийн усан хангамжийг бохирдуулсан байна. Албан бус уул уурхай бүхий сумдад зориулсан тусгай хөтөлбөр боловсруулж уул уурхайн бусад компанийн хамтын хүчин чармайлтаар хэрэгжүүлэх, алтернатив буюу ажил эрхлэлтийн бусад хэлбэрүүдийг хөгжүүлэх санхүүгийн болон эрх зүйн орчин яаралтай бүрдүүлэх хэрэгтэй байна. Албан бус уул уурхай эрхэлж буй иргэд бол нийгмийн “орхидос” биш. Иймд тэдэнд зориулсан эрүүл мэндийн суурь үйлчилгээ, боловсрол, нийгмийн даатгалын цогц арга хэмжээг авах ёстой.
- УБ хотын агаарын бохирдлын өнөөгийн энэ түвшин үргэлжилсэн хэвээр байх нөхцөлд 15 сая тн CO₂-г шингээхийн тулд 5.1 сая га талбайд шилмүүст ой тариалах хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл, УБ хотод жил бүр хуримтлагдсан CO₂-г шингээхийн тулд Богд Хан уулын байгалийн нөөцийг 76 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц газрыг бий болгох шаардлагатай.

1.5. Боловсрол

- Хүүхдийг 6 настайгаас нь сургуульд сургах болсноор хөдөөгийн нэг бүл хоёр тусдаа амьдарч улмаар өрхийн эдийн засаг болон гэр бүлийн харьцаанд сөрөг хандлага давамгайлах болов.
- УБ хотын ядуу өрхийн бага болон дундаас доош шатны сургуульд суралцаж буй хүүхэд 2.1 км зам туулж байж сургуульдаа очдог байна.
- Коллеж, их, дээд сургуулийн оюутнуудын дөнгөж 15 % нь нийт хүн амын 40%-ийг бүрдүүлж буй ядуу, орлого багатай хэсгийн төлөөлөл байдаг.

1.6. Эрүүл мэнд

- 7497 эмчээс 4565 нь Улаанбаатарт байгаа бөгөөд нэг эмчид ногдох өвчтний тоо хөдөөд 3 дахин их байна.
- Ядуу өрхүүд нэг хүнд ногдох сарын хэрэглээнийхээ 2%-ийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 5%-ийг боловсролын үйлчилгээнд зарцуулж байна.
- Төв, Сүхбаатар, Дорноговь аймгийн 6 суманд шүдний өвчлөл маш их байсан ба 5-6 насныхны 94% нь шүдний ямар нэг гажигтай байна.

- 1999 онд хар тамхинд донтсон 45 хүн бүртгэгдсэн бол 2014 онд энэ тоо 410 болж даруй 9 дахин нэмэгдсэн байна.
- Өмнөх онтой харьцуулахад амаржсан эх 598 буюу 3 хувиар, төрсөн хүүхдийн тоо 294 буюу 4.2 хувиар буурчээ. Нялхасын эндэгдэл мөн оны үетэй харьцуулахад 33 хувиар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 32,3 хувиар өссөн байна.

1.7. Авлига

- Олон улсын "Транспарэнси интернэшил" байгууллагаас явуулдаг авлигын төсөөллийн индексийн судалгаагаар Монгол Улс дэлхийн 182 орноос 83-рт орсон байна..
- Монгол Улсад авлига түгээмэл үзэгдэл болсон гэж нийт иргэдийн 81.4 хувь нь үзэж байна.
- Авлигын гэмт хэргийн давталт буюу үйлдлийн тоо нэмэгдэж байгаа нь төрийн байгууллагын дүрэм журмын гажуудал, үйл ажиллагааны ил тод бус байдал нь эдгээр хэргийг дахин давтан үйлдэгдэхэд хүргэж байна.
- Төрийн өндөр албан тушаалтны авлига өсчээ.

1.8. Байгаль орчинтой холбогдсон орлого, зарлага

Байгаль орчны орлого, зарлагын тэнцэл буюу бид байгалиас юу авч, байгальд юу өгч байгаа талаар статистикийн албан ёсны мэдээ одоогоор байхгүй байна. Монгол Улсын тогтвортой хөгжлийн номлол, үзэл баримтлал, бодлогыг боловсруулахад энэхүү тоо баримт, түүн дээр тулгуурласан эрсдлийн дүн шинжилгээ нэн чухал шаардлагатай юм.

Дүгнэлт

Дээр дурдагдсан хүний хөгжил, байгаль орчны эмзэг байдалтай холбогдсон бүх статистик тоо баримтад тулгуурлан дараах гол дүгнэлтүүд, цаашид зайлшгүй хэрэгжүүлэх чиглэлүүд гарч байна. Үүнд:

Хөгжлийн бодлогодоо яаралтай засвар оруулж “даацтай буюу хөгжлийн” бодлого руу амаар биш ажил хэргээр орох цаг нэгэнт тулж ирсэн байна. Цаг хугацааны хувьд 2012-2016 он даацтай, хүмүүсийн оролцоотой тэнцвэртэй хөгжлийн бодлогын гарааны жилүүд болох ёстойг бид өмнөх Амьдрал хөтөлбөртөө тунхаглаж байсан. Энэ тунхаглал маань ажил хэрэг болж, Байгаль орчин Ногоон хөгжлийн яамыг үндсэн чиг үүргийн яам болгож, Монгол Улсын Ногоон Хөгжлийн баримт бичгийг УИХ-аар батлуулж чадлаа. Одоо бид бодлогоо хэрэгжүүлэх л чухал байна.

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫ

УХА0122

№ 789

2016 он 24 сар 27

Байгаль орчны доройтол, эмзэг байдлын өнөөгийн түгшүүртэй байдал цаашид зогсолтгүйгээр, хурдацтай муудах магадлал маш өндөр байна. Эдгээр нь зөвхөн уул уурхай бус бусад маш олон хүчин зүйлийн нөлөөтэй байгааг харгалзан “ур амьсгалын өөрчлөлтийн өндөр” мэдрэмжтэй төрийн бодлого боловсруулах цаг тулж ирсэн байна.

Албан ёсоор гурван хүн тутмын нэг нь ядуу гэдэг ~~и~~ ядуурах магадлалтай эмзэг хэсгийг тооцвол 50% илүү гарах нийгмийн ~~том~~ архагшсан өвчин болсон ядууралд хандах төрийн бодлогыг өөрчлөх цаг болсон байна. Ядуурал нь зөвхөн орлогын ядуурал бус олон хүчин зүйлэс хамаарсан олон хэмжээстэй ядуурал, тухайлбал, байгаль-орчны эмзэг байдал, доройтол, эрүүл мэндийн суурь үйлчилгээний хүрэлцээгүй байдал, “ядуусын” өвчлөл /хоол хүнс, илчлэг, чанар гэх мэт/, боловсролын хүртээмж чанар, эрчим хүч, ариун цэврийн ~~байгууламж~~ ^{өдөр} амьдралын тухтай орчин, дэд бүтэц гэх мэтээс хамаарсан ядуурал болон хувирсан байна. Гэтэл үүнийг мөнгө төгрөг тараах болон нийгмийн халамжийн бодлогоор шийдвэрлэхгүй нь тов тодорхой байна.

“Хөгжлийн төөрөгдөлд” орсон Монгол Улсыг хөгжлийн зөв замд нь оруулах ганц л гарц бий. Энэ нь хөгжлийн бодлого “даацтай, оролцоотой, тэнцвэртэй” гэсэн хүн төрөлхтөн яг одоо эрчимтэйгээр хэрэгжүүлж буй Зүйлийн агуулгаар баяжуулж Монгол хүн Монголдоо эрүүл, аюулгүй орчинд сайхан амьдрах тухай ИЗНН-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр биелэлээ олно.

ХОЁР. “АМЬДРАЛ”

ИЗНН нь үндэсний язгуур эрх ашиг, ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэн, байгальтай харьцах үндэсний уламжлалт сэтгэлгээ, хандлагаа эрхэмлэн хөгжүүлэгч, нийтийн болон хувийн өмчид суурилсан тогтвортой эдийн засаг, ногоон хөгжлийг тэргүүлэх бодлогоо болгон тууштай хэрэгжүүлэгч, нийгмийг шинэчлэгч, либерал ардчилсан үзэл баримтлал бүхий нам мөн.

Бидний эрхэм зорилго : Ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан, экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн замд улс орноо хөтөлж, хүн бүр өөрийн хүсэл эрмэлзлэл, авьяас чадвар, шударга хөдөлмөрийнхөө үрээр Монголдоо сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.

Хүн-байгалийн хүйн холбоо, арга билгийн шүтэлцээт харилцаанд тулгуурласан уламжлалт ухаанаар сэтгэдэг, байгалийн баялгийг өөрсдийн мэдэл,

оролцоотойгоор, мэдлэгт суурилсан, амьдрах орчинд халгуй аргаар ашиглах замаар амьдралынхаа хэрэгцээг хангаж чадах **МОНГОЛ ХҮН, МОНГОЛ-НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ-** д бид итгэдэг.

МОНГОЛ-НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ нь экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн асуудлаас бүрдсэн хоорондоо харилцан хамааралтай дэд тогтолцоо бүхий хувь хүн төвтэй хөгжлийн гарцын бодлого юм. Дэлхий нийт ч ЭНЭ замаар явахаа тунхаглачихлаа.

Хуучин намууд бэлэн мөнгө цацах богино настай бодлого явуулж, ард олныг улам ядуу дорой, бэлэнчлэх, төрийн гар харах, гуйланчлах сэтгэлгээнд оруулсан буюу оруулсаар байгаа бөгөөд биднийг байнгын ядуу байлгах гэсэн атаг бодол өвөрлөж төрийн хөрөнгөөр тоглож байна. Бид Монгол хүнд ажил хийснийх нь төлөө амьжиргаатай байлгах цалинг нь олгох замаар ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, эрүүл бодлого баримтлана.

Бидэнд хэдэн үеэрээ ядуу байж хүлээх боломж байхгүй, бидэнд тийм цаг байхгүй, бидэнд тийм тэнхээ алга. Бид бүгдээрээ одоо хамтдаа, зоригтой өөрчлөлтийг эргэлт буцалтгүй хийж байж амжилтад хүрнэ.

Иргэний Зориг Ногоон Нам нь дэвшилтэт үзэлтэй олон мянган шударга иргэдийг нэгтгэж экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэн улс орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй зоримог алхмуудыг санал болгож байна.

АЗ ЖАРГАЛТАЙ МОНГОЛ ХҮН-ИЙ ТӨЛӨӨ ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ АМЬДРАЛ хөтөлбөрөө шинэчиллээ. Хүн төрөлхтний хөгжлийн өнөөдрийн сонголт болсон даацтай, оролцоотой, тэнцвэртэй хөгжлийн замын гол зангилаа бодлогууд энэхүү хөтөлбөрт маань нэвт шингэсэн билээ.

Нэг. Хариуцлагатай, Хүчирхэг, Шударга төрийн тогтолцоог бий болгохын төлөө ИЗНН:

1.1 Парламентын засаглалыг төгөлдөржүүлнэ.

- Иргэдээс шууд сонгогддог парламентын Дээд танхим, Дээд танхимиын суудлын хувиар байгуулагдах байнгын ажиллагаатай Доод танхимтай байхыг дэмжинэ.

1.2. Төрийн өндөр албан тушаалтны дархлааг жирийн иргэнтэй адил хэмжээнд аваачина.

- Хуулийн байгууллагыг улс төрийн нөлөөллөөс ангид байлгаж, хараат бус шударга хуулийн тогтолцоог бий болгоно.
- Авлигатай тэмцэх байгууллагыг улс төр болон бүлэглэлийн хараат байдлаас ангид ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

**ОЛ УЛСЫН
АУДИТИН ГАЗАР**

ХА0122

- УИХ-ын гишүүн зэрэг өндөр албан тушаалтан зөвхөн үйлдэл дээрээ баригдвал авилгын хэрэгт сэжиглэгдэх тухай заасан хуулийн заалтыг хүчингүй болгоно.
- Төрийн өндөр албан тушаалтнуудын ~~дээрээнийгийн~~ эрх ашгийн зайлшгүй шаардлагын хэмжээнд хүртэл бууруулж, гэмт үйлдлийн талаар хүлээх хариуцлагыг нийтийн жишигт оруулна.
- Улс төрийн намууд төрийн өндөр албан тушаалд нэр дэвшүүлж сонгогдсон, томилуулсан албан тушаалтныхаа төлөө хүлээх хариуцлагыг тодруулан чангатгаж, авлигын эсрэг хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3. Төрийн иргэдийнхээ өмнө хүлээх хариуцлагыг жинхэнэ утгаар нь бий болгоно.

- Төр, төрийг төлөөлдөг бүх субъект нь иргэнийхээ өмнө хариуцлага хүлээдэг тогтолцоог бүрдүүлж хуульчилна.

1.4. Яамдад мэргэжлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлнэ.

- Яамдын тоог цөөрүүлэхийн зэрэгцээ, мэргэшсэн албан тушаалтан, мэргэжлийн баг удирддаг тогтолцоог эрх зүйн хувьд баталгаажуулна. Мэргэжлийн Засгийн газрын тогтолцоог дэмжинэ.
- Төрийн бодлого, хариуцлагыг хүн ардын амьдралын аюулгүй байдал, чанартай нягт холбож, Засгийн газар жил бүр иргэдийн амьдралын түвшин, түүний өөрчлөлтийн тайланг хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийн хамт нийтээр хэлэлцүүлж, үр дүнг хариуцах чанд журам тогтооно.

1.5. Төрийн мэргэшсэн албаны тогтолцоог бий болгоно.

- Төрийн бодлогын залгамж чанар, төрийн албаны тогтворт суурьшилтай, мэргэшсэн, чадварлаг тогтолцоог бүрдүүлэхийн тулд нийтийн албыг намын харьяаллаар талцуулан халж, сэлгэдэг буруу зуршлыг хална.
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэр үндэслэлгүй болох нь тогтоогдвол үүдэн гарах хохирол, гэм хорын тодорхой хувийг тухайн этгээдээр барагдуулдаг эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.6. Улс төрийн намыг хариуцлагажуулна.

- Улс төрийн албан тушаалд намаас нэр дэвшиж сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнуудад хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бий болгоно.
- Улс төрийн албан тушаалд намаас нэр дэвшин ажиллаж байгаа этгээд намын дүрэм, Мөрийн хөтөлбөрийг зөрчсөн гэж үзвэл эгүүлэн татаж, оронд нь нэр дэвшүүлнэ.

1.7. Иргэдийн мэдээллийг урамшуулна.

- Хууль бус үйл ажиллагааны талаархи иргэдийн баримт нотолгоотой мэдээлэлд урамшуулал өгөх тогтолцоог хэрэгжүүлж, иргэн, хууль хяналтын байгууллага хоорондын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргана.

1.9. Орон нутгийн засаглалын эрх мэдлийг жинхэнэ утгаар нь хөгжүүлнэ.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг иргэд шууд сонгодог, эгүүлэн татдаг тогтолцоог бий болгоно.
- Аймаг, бүсийн хөгжлийн 2016-2026 оны хөтөлбөрийг батална. Зөвхөн цаасан дээр л үлддэг урьд өмнөх хөтөлбөрүүдийн хувь заяаг давтахгүйн тулд 5 бүсийн хөгжлийн асуудал хариуцсан Захирагч нарыг Сайдын зэрэглэлтэй тэнцэхүйц эрх мэдлээр хангаж ажиллуулна.
- Уул уурхайн салбараас олох орлогын 40 хүртэлх хувийг тухайн орон нутгийн хөгжилд зарцуулдаг, иргэд нь оролцдог, хяналт тавьдаг хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Газар ашиглалтын орон нутгийн бодлогыг төрийн хэмжээнд нэгтгэж бэлчээрийн, газар тариалангийн, байгалийн нөөц ашиглалтын газруудыг нэгдсэн системээр зохицуулна.

1.7. Иргэдийнхээ үнэн зөв мэдээлэл авах эрхийг баталгаажуулна.

- Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг баталж гаргана.
- Мэдээлэл өгөгч/нууц эх сурвалжийг хуулиар хамгаална.
- Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

МОНГОЛ У
ҮНДЭСНИЙ АУДИ

УХА012

No. 28

16.04.2016

20.04.2016 сар

Хоёр. Иргэдээ тэтгэсэн эдийн засгийн бодлого явуулна. Үүний тулд ИЗНН:

2.1. Халамжийн бодлогыг ялгавартай явуулна.

- Өндөр насын тэтгэврийн доод хэмжээг амьжирааны ~~бодит түвшингийн газар~~
хангахуйцаар үе шаттайгаар нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
2
- Ядуу, нэн ядуу өрхөд нэмэлт хүнс олгох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2. Төр, хувийн хэвшлийн түншлэл, илтгэлцүүрийн өнөөгийн тогтолцоог эрс өөрчилнэ.

... өдөр

- Төр, хувийн хэвшлийн хооронд бүтээн байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрийн хөрөнгө оруулалтын чиглэлээр юу хийж болохыг тодорхойлсон, эргэн төлөлт, Засгийн газрын баталгааг төсөвтэй уяж зохицуулсан Төр хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Төрийн бизнес дэх оролцоог хязгаарлаж, төрийн захиргааны байгууллагаас зайлшгүй өгөх шаардлагатай зөвшөөрлийн шат дамжлагыг цөөрүүлж, зөвшөөрлийн тогтолцоог мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

2.3. Гадаадын хөрөнгө оруулалтыг тууштай дэмжинэ.

- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих Монгол Улсын хууль эрх зүйн орчин, бодлогын тогтвортой байдлыг хангаж ажиллана.
- Гадаадын хөрөнгө оруулагчтай гэрээ хийх Үндэсний консерциумын бодлогыг тууштай дэмжин хэрэгжүүлнэ.
- Хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн хэрэгжилтийг Хөгжлийн төслүүдтэй уялдуулан салбарын бодлогуудад тусгаж, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллана.
- Дэлхийн түвшний тогтвортой, хариуцлагатай уул уурхайн дэд бүтцийг дэмжинэ.

2.4. Дэлхийн дэвшилтэт технологи, арга ажиллагааг Монгол орны онцлогт тохируулан нутагшуулна.

- Дэлхийн хамгийн сүүлийн үеийн өндөр бүтээмж бүхий шилдэг технологи, орчин үеийн дэвшилтэт арга ажиллагааг уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлж нутагшуулна.

- Нүүрсний эрчим хүчний цэвэр технологи, нүүрсийг хийжүүлэх, нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх, нүүрсийг шингэрүүлэх, коксжуулах технологи зэрэг дэвшилтэт технологиудыг нутагшуулах бодлого, үйл ажиллагааг бүхий л талаар дэмжиж, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.
- Ус, эрчим хүчний зарцуулалтыг хэмнэлттэйгээр дахин боловсруулах технологийг үйлдвэрлэлийн бүхий л салбарт нэвтрүүлэх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжинэ.
- Ган хайлах, нефть нэрэх, нүүрс боловсруулах зэрэг үйлдвэрлэлийн суурийг тавина. Үүний үндсэн дээр жижиг, дунд үйлдвэрийн ~~хөгжил~~²⁰ он ~~24~~¹⁶ сэр эрчимжинэ.
- Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүднээс компанийн засаглал, технологи, хүний нөөц, худалдаа, өрсөлдөөн гээд хувийн хэвшил шударгаар хөгжих бодлогын таатай хөрсийг бий болгоно.
- Бионүүрсний үйлдвэрлэл, хэрэглээг төрөөс татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.

МОНГОЛ УЛ
ҮНДЭСНИЙ АУДИ

УХА0121

№ 121

20 он 24 сэр

2.5. Дотоодын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хамгаалах, дэмжих бодлого явуулна.

- Жижиглэнгийн худалдаа, үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал зэрэг үйлчилгээний салбаруудад ажлын байрыг олон мянгаар нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийх таатай нөхцлийг бүрдүүлнэ.
- ХАА-н салбарыг экспортын чиглэлээр хөгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- Эцсийн орлогоос малчдад хүртээх экспортын хоршоог бүхий л талаар дэмжинэ.
- Малаа эрүүлжүүлж, тэжээлийн эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар гадаад, дотоод зах зээл дэх нийлүүлэгч ба хэрэглэгчийг холбосон хангамж, нийлүүлэлтийн сүлжээг бий болгоно.
- Зах зээлийн мэдрэмжтэй, хөрвөх чадвар сайтай, зохистой сүргийн бүтэц бүхий малчдын бүлгийг төрийн бодлогоор дэмжих, малжуулах зээлийг төр, арилжааны банкны хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Малын хөлийн татвартай болно. Татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж цөлжилттэй тэмцэх, бэлчээрийг хамгаалахад зарцуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.

- Сум тус бүрт залуу малчдад зориулсан хөгжлийн төв байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг төрийн бодлогоор дэмжих замаар иргэн, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулна.
- Цахим малчны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн ~~санаачилгыг~~
~~ЫН ГАЗАР~~ төрийн бодлогоор дэмжинэ.
- Малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд ~~үйлдвэрлэлийг~~
дэмжинэ.
- Малчны залуу халааг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- Хаягдалгүй, цэвэр үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, малчин, тариаланчдыг хүлээмжийн хийн ялгаруулалтыг ~~багасгахад~~
~~оцуулсан хувь нэмрийг нь үндэслэн төрийн бодлогоор дэмжих эрх зүйн~~ орчинг бүрдүүлнэ.
- “Цагаан алт” болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжинэ.
- Сумын төвийн ажилгүй иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжих зорилгоор жижиг оврын тоног төхөөрөмжөөр хангах худалдаа үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлөх, хөнгөлөх бодлого хэрэгжүүлнэ.
- Малын үүлдээр угсааг сайжруулахад онцгой анхаарч энэ чиглэлийн эрдэм шинжилгээний ажилд бодлогын болон санхүүгийн дэмжлэг тууштай үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Малын үүлдээр угсааг сайжруулах, эрүүлжүүлэх үйл ажиллагааг малчдын хоршооны хамтын удирдлага, хяналтан дор хэрэгжүүлэх бодлогыг баримтлана.
- Сүү, цагаан идээг боловсруулах, малчид хоршоо нөхөрлөл байгуулах, жимс, ногоо тарьж боловсруулах санаачлагыг татвар, татаас, зээлийн бодлогоор дэмжинэ.
- Малчдын хоршоог дэмжсэн эрх зүй, эдийн засгийн оновчтой бодлогыг тодорхойлж, тууштай дэмжинэ.
- Малчдаас үндэсний үйлдвэрлэлд нийлүүлэх бүтээгдэхүүний бэлтгэл нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог малчдын хоршооны бүтцэд тулгуурлан бүрдүүлнэ.
- Малжуулах хөтөлбөрийг ил тод, шударга, хүртээмжтэй явуулахад хяналт тавихад иргэний болон ИНБ-ын оролцоог хэрэгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

- Гадаад худалдаа, түүний дотор хил худалдааг аймаг, бус нутгийн хөгжлийн нэг гол хөшүүрэг гэж үзэн худалдаа, тээврийн нэхцлийг хөнгөвчлөх, хилийн боомтуудыг үйл ажиллагааг бизнес эрхлэгчдэд таатайгаар хөгжүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх, худалдааг дэмжсэн чухал алхам болно.
- Монгол улсдаа өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлэн “Ногоон экспорт” сүлжээ бий болгон инновацийн бүтээгдэхүүнээ экспортлож гадаад зах зээлээс орж ирэх валutyн урсгалыг эрс нэмэгдүүлнэ.
- Жимс жимсгэний аж ахуй байгуулах, ховор ба ховордсон эмийн ургамал, гоёл чимэглэлийн ургамал тариалах иргэд байгууллагыг бүх талаар дэмжиж, таримал ба зэрлэг жимс ургамлын инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад тус дэхем үзүүлнэ.

2.6. Хувьчлалыг шударга, ил тод явуулна.

- Төрийн өмчит компаниудын хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулж шударга, ил тод явуулна.

Гурав. Ногоон хөгжлийн бодлогоо тууштай үргэлжлүүлнэ. Монгол орны нөхцөлд тохирсон ногоон хөгжлийн загвар, хэм хэмжээг эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт бий болгож, ногоон хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг улам боловсронгуй болгон, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого явуулна. Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ. Үүний тулд:

3.1. Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийг бууруулах чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг бүхий л талаар дэмжинэ. УИХ-аар баталсан “Ногоон хөгжлийн үзэл баримтлал”-ын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна:

- 2020 он хүртэлх хугацаанд байгаль орчинд оруулах хөрөнгө оруулалтыг нийт хөрөнгө оруулалтын 20%-д хүргэнэ.
- Эрчим хүчний үр ашгийг 2020 он гэхэд 20 хувиар дээшлүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг /өнөөгийн байдлаар 4.3% байна/ эрс нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж 2020 он гэхэд 20%-д хүргэнэ.
- Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн цахилгаан станц барих, цөмийн түлш үйлдвэрлэх, цөмийн хаягдлыг байршуулахыг хатуу хориглоно.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫ

УХА0122

№ 789
2018 он 04 сар 07

- Засгийн газрын худалдан авалтын буюу бидний нэрлэж заншсанаар тендерийг шударга болгохоос гадна “ногооруулж”, 2016^т оноос эхлэн Засгийн газрын худалдан авалтанд “ногоон худалдан авалт”^{тусгайлан оруулж 2020 он гэхэд 20 хувь болгоно.}
- Засгийн газрын ногоон худалдан авалтыг 20 хувьд хүргэнэ. Дотооддоо үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй ижил төстэй импортын бараа бүтээгдэхүүнийг хязгаарлах бодлого явуулна.
- 2020 он гэхэд хулэмжийн хийн ялгаруулалтыг 20 хувь багасгаж, энэ чиглэлээрхи бодлого, үйл ажиллагааг бүх шатанд дэмжинэ.

3.2. Агаарын бохирдлыг үе шаттайгаар, эрчимтэй бууруулна.

- Улаанбаатар, бусад томоохон хотуудын агаарын болон орчны бохирдлын асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.
- Төв, суурин газрын барилгын дулаан алдагдлыг 20 хувиар бууруулна.
- Улаанбаатар хот, бусад төвлөрсөн суурин газруудад агаарын бохирдлоос иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэхийн тулд бүх сургууль, цэцэрлэг, үзвэр үйлчилгээний газрууд, ахмадын байгууллагуудад “ЭРҮҮЛ МЭНДИЙН КОКТЕЙЛЬ” хөтөлбөрийг хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх бодлого явуулна.
- Улаанбаатар хот болон бусад суурин газрын ногоон байгууламжийн талбай хэмжээг эрс нэмэгдүүлнэ. Тарьсны дараахи арчилгаа, усалгаанд хөрөнгө оруулалт хийнэ.

3.3. Ногоон барилгыг концессоор барих ажлыг бүх талаар хөхүүлнэ.

- Ногоон барилга гэж үнэлэгдэн тодорхой зэрэглэл тогтоогдсон барилгыг урамшуулах эдийн засгийн механизм, тэр дундаа татварын хөнгөлөлтийн системийг буй болгоно.
- Цаашдаа шинээр баригдах барилгуудад (ялангуяа цэцэрлэг, сургууль зэрэг боловсролын барилгуудад) ногоон барилгын минимум зэрэглэлийг зайлшгүй хангасан байх стандарт шаардлага тавьж мөрдүүлнэ. Ингэснээр эрчим хүчиний зарцуулалтыг 40-50 түүнээс дээш хувь бууруулах боломж бүрдэнэ.

3.4. Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.

- Эрдэс баялгийн салбарын нийгэм-байгаль орчны нөлөөлөл, нөөц ашиглалт, нөхөн сэргээлт, техник технологийн стандартуудыг шинэчлэхдээ өндөр хөгжилтэй орнуудын стандарт, техник технологийн шинжлэх ухааны үндэслэлтэй өөрийн хөрсөн дээр буулгаж шилжүүлнэ.
- Ашигт малтмалын хайгуулын лиценз олгоходо орон нутгийн байгалийн нөөцийн судалгаа, тооцоо, менежментийн төлөвлөгөөг үндэслэлж түүнтэй

уялдуулан олгож байх тогтолцоо бий болгон, энэ ажилд Нутгийн өөрөө удирдах байгууллага тэргүүлэх үүрэг, эрхтэй оролцох нөхцөл бүрдүүлнэ.

- Ашигт малтмалын тухай хуулинд ашиглалтын лиценз олгоходо орон нутаг дахь түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах шаардлагыг харгалзан үзэх, тухайн газарт түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулах, илэрсэн түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах ажилд шаардагдах зардлыг тухайн аж ахуйн нэгжээр төлүүлэн эрх зүйн үндэстэй болно. Чингэхдээ өөрийн эх нутагт хүчин төгөлдөр хэрэгжигдэж буй холбогдох бүх стандартыг Монгол Улсад ч бүрэн 20... он 04 сар зарим баримтлана.
- “Хаягдсан талбайг нөхөн сэргээх санаачлага” төслийг эхлүүлж эдгээр талбайн нөхөн сэргээлтийг мэргэжлийн өндөр төвшинд хийх санхүүжилтийг уул уурхайгаас олж буй орлогоос болон хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх механизмыг бий болгоно.
- Уул уурхайн хүнд машин механизмын гаалийн татвар дээр экологийн З хувийн татварыг нэмж авах, татвараараа байгаль орчноо хамгаалахад зарцуулах бодлого явуулна.

3.5. Монгол орныхоо газар ашиглалтын нэгдсэн бодлогыг бий болгоно.

- Монгол Улс, орон нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, төлөвлөгөөтэй уялдуулан нийт Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар ашиглалтын бодлогыг боловсруулна.
- Газрын гадаргын болон хэвлийн ашиглалтын зөрчлийг арилгахын тулд бус нутгийн болон улсын газар ашиглалтын бодлогыг тодорхой болгож, ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулж болох талбайг хязгаарлана.
- Монгол Улсын цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг удирдлага болгон бүх сумдад ой үржүүлгийн газрыг санаачилан байгуулж 145 сумын төвийг ногоoruулан цаашид элсний нүүдлийг тогтоон барих ажлыг орон нутаг бүрт төр, төрийн бус байгууллагууд, ард иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор дэс дараатай хэрэгжүүлнэ.

3.6. Иргэдийн оролцоонд түшиглэсэн ашиглалт, хамгаалалтын бодлого явуулна.

- Байгалийн нөөцийн даацтай ашиглалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс орон нутгийн иргэдэд тулгуурласан, байгалийн нөөцийн удирдлагын эрхийг тэдэнд өгсөн үзэл баримтлалыг нэвтрүүлэх. Үүнд: (i) байгалийн баялгийг хамгаалагч, ашиглагч, эзэмшигчид нь үйл ажиллагаагаа нутгийн өөрөө удирдах байгууллагад тайлагнадаг, цаашдын үйл ажиллагааг хамтран шийддэг тогтолцоонд шилжинэ, (ii) байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин нутагтаа байгалиа хамгаалах, амьжиргаагаа

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ
УХА0122

No 78
20... он 04 сар

дээшлүүлэх, бие биедээ туслах, хамтран ажиллах зорилготой нэг нутаг усны айл өрхүүдийн нөхөрлөл жинхэнэ утгаараа байгуулагдах үйл явцыг дэмжинэ, (iii) байгаль хамгаалах, бэлчээр ашиглагчдын болон сийн нөхөрлөлүүдийг дэмжих ажлыг эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор дэмжих, орлого нэмэгдүүлэх боломжийг бий болгосноор ажлын байр нэмэгдэнэ.

- Бутлаг ургамлыг тарьж хашаажуулах “Эко хашлага” хөдөлгөөнийг жил бүр өрнүүлэн хууль журамд заасан урамшууллын системийг боловсронгуй болгон хэрэгжүүлнэ.

3.7. Эко, органик төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ.

27. өдөр

- Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.
- Органик хүнсний үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжих бодлого явуулна. “Чацааргана” зэрэг брэндийг хөгжүүлж, дэлхийн зах зээлд гаргахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

3.8. Тусгай хамгаалалттай газар нутгийг тэлж, менежментийг нь бодлогын шинэ түвшинд гаргана.

- 2030 он гэхэд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 30 хувийг тусгай хамгаалалтанд авна гэсэн зорилтыг наашлуулж 2020 он болгох зорилт хэрэгжүүлнэ. Улсын тусгай хамгаалалттай газарт газар нутгийн хэмжээгээр биш бодит судалгаанд сууриссан хамгаалалт, ашиглалтын шинэ менежмент нэвтрүүлнэ.
- Хамгаалалтын ашиглалтын үйл ажиллагааг зохицуулсан үүргийг аль болох нутгийн өөрөө удирдах байгууллага, шинжилгээ судалгаа, аялал жуулчлалын төрийн бус байгууллагуудад шилжүүлнэ. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоонд түшиглэсэн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ. Үүний тулд орон нутгийн өөрөө удирдах эрх үүргийг өргөжүүлэн, байгаль орчны удирдлагын төвлөрлийг сааруулна. Ингэснээр байгалийн нөөцийн тогтвортой даацтай менежментийг хөгжүүлэх, зөв зохистой эрхлэх талаар нутгийн өөрөө удирдах байгууллага бэхжих, бие даасан байдлын нөхцөл бүрдэнэ.

3.9. Байгаль орчноо хамгаалах уламжлалт арга ухааныг дэмжиж, иргэдийн боловсролд хөрөнгө оруулалт хийнэ.

- Байгаль орчны салбарын боловсон хүчний үнэлэмжийг өндөрсгэн, Байгаль орчны хууль тогтоомжийг сахиулах, сурталчлах зэрэг ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх чадварлаг нөөц боловсон хүчнийг бэлтгэх, дадлагажуулах тусгайлсан хөтөлбөрийг албан болон албан бус боловсролын хүрээнд хэрэгжүүлнэ.

- Орон нутгийн иргэд, малчдын хууль эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, өөрсдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, эрхийнхээ төлөө тэмцдэг, НӨУБ-ын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих чадварыг дээшлүүлэх зориолгоор иргэд, малчдын чадавхийг дээшлүүлнэ.
- Байгаль дэлхийгээ хүндлэн дээдэлж ирсэн өвөг дээдсийн уламжлалт ёс заншилд тулгуурлан залуу үеийнхэнд байгаль орчноо хайрлан хамгаалах, зохистой хэрэглээнд төлөвших, байгаль орчноо тэтгэн сайжруулах арга ухаанд суралцах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, амьдрах чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Эрдэс баялгийн салбарт хяналт-мониторингийн иргэний нийгмийн болон хөндлөнгийн хараат бус, мэргэжлийн тогтолцоог хөгжүүлнэ.

3.10. Бусад

- Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг 20 хувьд хүргэнэ.
- Ногоон хөгжилд зарцуулах зардлыг ДНБ-ний 2 хүртэлх хувьд хүргэнэ.
- Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайг 8.5 хувьд хүргэнэ.
- Ундны усны чанарыг сайжруулна.

Дөрөв. Нас, хүйс, шашин шүтлэг, намын харьялал, угсаа гарал, оршин амьдарч буй газрын байршил, бэлгийн чиг баримжаа, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй амьдрлан, сурч боловсорч, амьдралаа өөрөө зохиож, аз жаргалаа эрэлхийлэх тэгш боломж олгохыг бид зорино. **Ажилгүйдэл, ядуурлын эсрэг туштай ажиллахын тулд ИЗНН:**

4.1. Монгол хүнээ хөгжүүлэх, өргөх дэмжих бодлого явуулна.

- Залуучууд болон 45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийг 50% бууруулна. Нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг зогсоож, 35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд амьдралаа өөрчлөх бодитой дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Тэмүүлэл” сан байгуулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг авч сургадаг цэцэрлэг, дунд сургууль, MCYT-д шаардлагатай төсвийн зардлыг нь төсөвт суулгаж, шууд шилжүүлдэг болно.
- Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх замаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулна.

- Бэлэн мөнгө хавтгайруулан тараадаг халамжийн бодлогыг зогсоож, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нэн ядуу, ядуу иргэдийн амьдралын түвшинг өнөөгийхөөс хоёр дахин нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

4.2. Монгол айл өрхийг хөгжүүлэх, дэмжин тэтгэх бодлого явуулна.

- Өрхүүд сайн дураараа нэгдэн “хуримтлалын бүлэг” байгуулах, дундын буухиа зээлийн сан, бичил болон өрхийн бизнес эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилтийн бусад бүтцүүд байгуулахыг төрөөс бүх талаар дэмжиж, “Иргэний хөгжлийн зээлийн сан”-тай холбож, зээл авах, төслийг сонгон шалгаруулах, хэрэгжилт, хяналт-мониторинг хийх зэрэг бүх шатанд иргэдийн оролцоог хангаж ажиллах бодлого барина.
- Залуусыг мэргэшүүлэх, мэргэжилтэй болгох чиглэлээр MCYT-ийг түшиглэн богино хугацааны, тэтгэлэгтэй сургалтанд хамруулах бодлого хэрэгжүүлнэ.
- Хот, суурин газруудад ганц бие болон залуу гэр бүл өөрсдийн сонголтоор амьдрах Түрээсийн орон сууцыг олноор барих ажлыг төрөөс дэмжинэ.
- Залуу гэр бүлийг дэмжих цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- Шинэ хүүхэд төрсний дараа эцэгт нь олгодог цалинтай чөлөөний хугацааг сунгах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Хүүхдийн сүүний газар, сувиллын эмнэлэгүүдийг хот, хөдөөд хувийн хэвшлийн хувь оролцоотойгоор байгуулна.
- Хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор спортын ордон, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах ордон, лаборатори байгуулах ажлыг хувийн хэвшлийн хувь оролцоотойгоор байгуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Залуу эцэг эхийн, хүүхдийн боловсрол хүмүүжлийн талаарх сурган хүмүүжүүлэх мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж буй хувийн хэвшил, ИНБ-ын үйл ажиллагааг дэмжинэ.

4.3. Нийгмийн баялгийн шударга хуваарилалт, тэгш хүртээмжийн бодлого явуулна.

- Нийгмийн баялгийн шударга зарчимд нийцсэн хуваарилалтын бодлого баримталж, түүний үр дүнг нийтэд ил тод мэдээлнэ.
- Нийгмийн эмзэг бүлгийн халамж, тэтгэмжийг оновчтой болгож дээшлүүлэхийн зэрэгцээ нийгмийг тэжээлгэн тэтгүүлэх, бэлэнчлэх сэтгэлгээнээс цэвэрлэхэд чиглэсэн үр нөлөөтэй бодлого явуулж, нийгмийн ардчилсан тогтолцооны гол давуу чанар нь нийгмийн гишүүд амьдралаа бүтээх эрх чөлөө буюу хариуцлага мөн болохыг үндэсний үзлийн өв болгон мэргэшүүлэлт, ажил эрхлэлт, хөдөлмөрийн үнэлгээний бодлого явуулна.

- Засгийн газар жил бүр иргэдийн амьдралын түвшин, түүний өөрчлөлтийн тайланг хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтийн хамт нийтээр хэлэлцүүлж, үр **МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН**

УХА0122

№ 789

16.04.2022

4.4. Гэр бүлийг хөгжлийг бүхий л талаар дэмжинэ.

- Иргэдийн өөрийн өмчлөлийн газартая тарьсан модыг үнэлгээжүүлж, үл хөдлөх хөрөнгөд тооцон зах зээлийн эргэлтэд оруулна.
- Хүүхдийн сүүний газар, сувиллын эмнэлгүүдийг хот, хөдөөд хувийн он цар хэвшлийн хувь оролцоотойгоор байгуулна.
- Хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор спортын ордон, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах ордон, лаборатори байгуулах ажлыг төрөөс болон хувийн хэвшлийн хувь оролцоотойгоор байгуулна.
- Залуу эцэг эхийн, хүүхдийн боловсрол хүмүүжлийн талаарх сурган хүмүүжүүлэх мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж буй хувийн хэвшил, ИНБ-ын үйл ажиллагааг дэмжинэ.
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг эрс нэмэгдүүлэх, шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудад хүүхдийн цэцэрлэг, сургуулийг барих, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.
- Улаанбаатар хотыг ногооруулах 1 сая мод хөтөлбөрийг иргэн, гэр бүл, төр болон төрийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх бодлого явуулна. Хотын иргэн бүр өөрийн модтой болно.
- Гэр хорооллын амины орон сууц, таун хаустай айл өрх бүр өөрсдөө цахилгаан үйлдвэрлэгч болох боломжийг бүрдүүлэхийн тулд ухаалаг сүлжээ (Smart grid) хөгжүүлснээр өрх бүр нарны хавтанг дээвэр дээрээ суурилуулж, түүгээр үйлдвэрлэгдсэн эрчим хүчийг шууд цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд нийлүүлдэг, нийлүүлсэн цахилгааны хэмжээг тоолж баталгаажуулдаг ухаалаг сүлжээнд холбогдох боломжтой болгоно.

4.5. Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлд эрс өөрчлөлт хийнэ.

- Аймаг, дүүргүүдэд олон улсын жишигт нийцсэн лаборатор бүхий Нийгмийн Эрүүл мэндийн төвүүдийг байгуулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий үндэсний цогц бүтцийг бий болгох бодлого хэрэгжүүлэх.
- Сум бүрт биеийн тамир, спортын заал, ил талбай барьж, эрүүл ахуйн мэргэжилтэн ажиллуулна.
- Хувийн хэвшлийн оролцоотойгоор нийслэлд хүүхдийн эмнэлэг, дүүрэг бүрт нэгдсэн эмнэлэг шинээр барих үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- Эх барихын болон НҮЭМ-ийн нэн шаардлагатай эм хэрэгслийн санхүүжилтийг төсвөөс бүрэн хариуцдаг болно.

- Эмнэлгийн тусlamж үйлчилгээнээс алслагдсан хүн амд зориулсан “Эхийн амаржих байр”-ны зардлын санхүүжилтийг төсвөөс бүрэн хариуцдаг болно.
- Эмнэлэг, тусlamж үйлчилгээний олон улсын стандартыг Монголын эрүүл мэндийн салбарт нутагшуулах ёе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Анагаах ухааны их, дээд сургуульд сувилагч мэргэжлээр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, шаталсан сургалтын хэлбэрээр сувилагчдыг бэлтгэх тогтолцоог дэмжиж, эмч, сувилагчийн зохистой харьцааг 1:2 бүрдүүлнэ.
- Өндөр хөгжилтэй оронд урт, богино хугацааны сургалтанд ~~наар~~ хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоог тасралтгүй нэмэгдүүлэх, гаднаас өндөр ур чадвартай мэргэжилтнийг урьж эх орондоо ажиллуулах бодлогыг тууштай дэмжинэ.

4.6. Эрүүл мэндийн даатгалын цоо шинэ тогтолцоо руу шилжинэ.

- Төрөөс даатгалын төлбөрийг нь хариуцахаар хуульчлагдсан /хүүхэд, тэтгэврийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хугацаат цэргийн албан хаагч, хүүхдээ 2 нас хүртэл асарч буй эхчүүд гэх мэт/ даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалыг нэмэгдүүлнэ.
- Ажилгүйчүүдийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмжээс шимтгэл авдаг журамд шилжинэ.
- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторт ажиллагсдыг эрүүл мэндийн даатгалд хамруулна.
- Төрөлтийг эрүүл мэндийн даатгалд хамруулна.

4.7. Нийгмийн даатгалыг бүхэлд хариуцлагажуулж, хүний төлөө үйлчилдэг болгоно.

- Тэтгэврийн даатгалын нэрийн дансны мэдээллийг даатгуулагчдад хүргүүлэх, даатгуулагч нь нэрийн дансан дахь хурумтлалаа бүрэн захиран зарцуулах, гэрээслэлийн дагуу өв залгамжлагчдаа шилжүүлэх, орлогод тооцсон хүүг ил тод мэдээлэх зэргийг зохицуулсан эрх зүйн шударга орчинг бүрдүүлнэ.
- Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх замаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулна.
- Гадаад оронд Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол иргэдийг нийгмийн даатгалд хамруулах хууль эрх зүйн зохицуулалтыг хийнэ.
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг барьцаанд тавих, нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах зэрэг үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар хатуу хориглоно.

4.8. Боловсролыг дээдэлдэг төсөв санхүү, бүтэц зохион байгуулалтын тогтолцоонд шилжих эрх зүйн өөрчлөлтийг хийнэ.

- “Монгол хүн судлал”-ыг дэмжин хөхүүлснээр Үндэсний боловсролын тогтолцоог өөрчлөх үндсийг бүрдүүлнэ.

- Монголын ирээдүй болсон хүүхэд, залуучуудын амьдралын чанарыг материаллаг талаас нь тахиж шүтэх ёс суртахууны хандлагыг өөрчлөх боловсролын цогц хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Багш нарын ажлын үнэлгээг боловсронгуй болгож, секц дугуйлан удирдсан, давтлага өгсөн, анги удирдсан, эцэг, эхтэй ажилласан зэрэгт нэмэгдэл урамшуулалтай болгох тогтолцоог бүрдүүлнэ.
- Багш нарыг давтан сургалтад тасралтгүй хамруулж, ур чадварыг нь дээшлүүлэх бодлого баримтлана.
- Багш нарыг орон сууцжуулах, хөдөө орон нутагт багшлах боловсон хүчинийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилго бүхий "Багш" сан байгуулна.
- Хувийн хэвшлээс боловсролын салбарт хөрөнгө оруулахыг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон оюутны үүсгэл санаачлага дээр үндэслэсэн бизнесийн төлөөллийн байгууллагын дэргэд "Оюутны ажил эрхлэлтийг дэмжих сан"-г байгуулж ажиллахыг төрийн бодлогоор дэмжинэ.
- Их дээд болон мэргэжлийн боловсролын сургуулийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан улс орны хөгжилд нэн тэргүүнд шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх үндэс суурийг тавина.
- Хувийн хэвшлийн зүгээс ойн зэрэг салбарын мэргэжилтэн бэлтгэх коллежийг байгуулах санаачилгыг бодлогоор дэмжинэ.
- Их, дээд сургууль, коллежид суралцагчдын бүтцэд ядуу өрхийн хүүхдийн хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар нийгмийн орлогын тэгш бус байдлыг багасгах арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлнэ.
- Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа тухайн салбарт хийгдсэн шинжлэх ухааны үндэслэлтэй эрсдлийн үнэлгээнд тулгуурлах боломжийг бүрдүүлж, салбарын эрдэмтдийн судалгаа, шинжилгээний үр дүнг төрийн бодлогод тусгана.
- Оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг дэлхийн түвшинд ойртуулж, шинжлэх ухаан, технологийн салбарын эрдэмтэн судлаачдын хөдөлмөрлөх нөхцөл, амьжиргааны баталгааг сайжруулна.

4.9. Соёл, урлагийг бүхий л салбарт дэмжинэ.

- Монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, хадгалан хамгаалах зорилгоор соёл, урлагийн салбарын хөгжлийг дэмжих төрийн бодлогын таатай орчинг бүрдүүлнэ.
- Монгол хүний оюуны үнэ цэнэтэй бүтээл, үндэсний бахархал болсон бүтээлд төрөөс хөрөнгө оруулалт хийнэ.
- Үндэсний соёл, урлагийг дэмжих замаар аялал, жуулчлалыг хөгжүүлнэ.
- Гадаад улс оронд Монголынхаа соёл, урлаг, ёс заншилаа сурталчлах үйл ажиллагааг төрөөс бүх талаар дэмжинэ.

4.10. Монголын баялгийг Монгол хүүхдийн хөгжилд зориулна.

- Хүүхдийн хүмүүжил боловсролд олон нийтийн оролцоо, нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгээс гадна тэр засгийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, үзвэр, ~~үйлчилгээний~~ газрууд, хувь хүн бүр хүүхдийн сайн сайхны төлөө үүрэг ~~хариуцлага~~ хүлээдэг механизмыг бий болгоно.

22

- Хүн ам төвлөрсөн газруудад хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг эрс нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэг, сургуулийг олноор барих бодлогыг барихыг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.
- Нийслэлд шинээр төрөх эмнэлэг барих үйл ажиллагааг бодлогын ~~хүрээнд~~^{өдөр} дэмжинэ.
- Анагаах ухааны сургуулиудад хүүхдийн эмч, сувилагч бэлтгэдэг болгоно.
- 3-5 настай 3 бүлэгт цэцэрлэгт дуу хөгжмийн багш, хүүхдийн эмч ажиллуулах тогтолцоог эрх зүйн хувьд бүрдүүлнэ.
- Хүүхдийн сүүний газар, сувиллын эмнэлэгүүдийг хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр хот, хөдөөд бий болго бодлогыг туштай хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор спортын ордон, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээний танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах ордон, лаборатор байгуулах ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулах ажлыг бодлогын хүрээнд дэмжинэ.
- Хөдөөгийн сургуулийн дотуур байрыг өргөтгөх замаар дотуур байрыг гэрийн нөхцөлд ойртуулан малчдын хүүхдийн ая тухтай сурч хүмүүжих орчинг бүрдүүлнэ.
- Хүүхдийн сургуульд элсэх нас, хичээлийн хөтөлбөр, улирлын амралтыг Монгол орны (хүний) онцлогт тохируулсан оновчтой тогтолцоонд шилжүүлнэ.

4.11.Өрх толгойлсон эмэгтэйчүүд/эрэгтэйчүүдэд бодитой дэмжлэг үзүүлнэ.

- Өрх толгойлсон эмэгтэйчүүд/эрэгтэйчүүдэд зориулсан орон байрны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Улаанбаатар хотоос орон нутагтаа буцах хүсэлтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд/эрэгтэйчүүдийг амьдрах таатай орчинг эрх зүйн бодлогоор дэмжинэ.
- Өрхийн хөдөлмөрийн чадвартай нэг хүний хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг хуулийн хүрээнд бүхий л чиглэлээр дэмжих бодлого баримтлана.
- Сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөн олгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Эдгээр өрхийн 0-5 хүртэл насны хүүхдийн хоол тэжээлийн хангамж, бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэн хэрэгжүүлнэ.
- Өрхийн сургуулийн насны нэг хүүхдийг сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслээр хангах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хот, суурин газрын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд өрх толгойлсон эмэгтэйчүүд/эрэгтэйчүүдийг татан оролцуулах замаар орлогын эх үүсвэрийг нь нэмэгдүүлэх бодлого баримталж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.
 - Сул чөлөөтэй ажлын байранд өрх толгойлсон эмэгтэйчүүд/эрэгтэйчүүдийн өрхийн гэр бүлийн гишүүдээс авч ажиллуулах санаачлага гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудыг “Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллага” – аар тодруулж, төрийн дэмжлэг үзүүлэх бодлогыг эрх зүйн орчныг сайжруулах замаар хэрэгжүүлнэ.
 - Өрхийн гишүүдийг өөрсдийгөө бие даан авч явах чадвартай иргэн болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг сургалтын байгууллагууд, ТББ-уудыг төрөөс тусгайлсан дэмжих бодлого явуулна.

4.12.ШИНЭ АХМАД ҮЕ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛНЭ.

- Ахмад үед зориулсан бодлого зөвхөн тэтгэврийн бодлогоор хязгаарлагдах ёсгүй. Ахмад үеийнхээ амьдралын арвин туршлага, мэдлэг, чадвар санаачлагыг дэмжин АХМАД ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ төрийн байгууллагууд, хувийн хэвшлийг түшиглэн байгуулна. Үүгээр монгол соёл, монгол чадвар, монгол мэдлэгээ хойч үедээ өвлүүлэн, улмаар дэлхийд түгээх боломжийг нээх бодлого явуулна.

4.13. Нийгмийн түншлэлийг эрчимтэй хөгжүүлнэ.

- Олон улсын хууль, конвенциор баталгаажсан Үйлдвэрчний эвлэлийн үндсэн эрх болох эвлэлдэн нэгдэж Үйлдвэрчний эвлэл байгуулах, төр, ажил олгогчидтой хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажил хаях эрхийг хүлээн зөвшөөрч нийгмийн түншлэлийн хэлбэрээр хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжсэн бодлого явуулна.
 - Хөдөлмөрийн хяналтын тогтолцоог бие даалган, хараат бус байдал, хяналтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох конвенцид нэгдэх бодлогыг хэрэгжүүлнэ.
 - Хөдөлмөр ба нийгмийн түншлэлийн чиглэлийн судалгааны ажлыг төрөөс дэмжинэ.

Дүгнэлт

САЙХАН АМЬДРАЛ - ТАНЫ СОНГОЛТ

ИЗНН-ын тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичгийн гол үзэл санаа, үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга замын талаар товч дурьдахад ийм байна.

ИЗНН төсвийн бодлого, макро эдийн засгийн бусад үзүүлэлтийн тооцоог дунд болон урт хугацаанд гаргах шаардлагагүй гэж үзлээ. Учир нь ~~эдгээрийн~~ хувьд аль хэдий нь хууль эрх зүйн болон макро бодлогын хүрээнд тооцооны хязгаарлалтууд хийгдсэн. Нөгөө талаас ИЗНН-ын санал болгож буй ~~бодлого~~ бодлогууд нь өнөөгийн төсөв-мөнгө, санхүүгийн эх үүсвэрийн түвшинд төсвийн болон бусад эх үүсвэрийг зохистой, үр ашигтай байршуулах, дахин байршуулах бодлогын реформ хийх замаар 2016-2020 онд хэрэгжих бүрэн боломжтой. Гэхдээ өнөөдрийн амьдрал дээр суурилсан асуудлуудыг шийдэхгүйгээр маргаашийн, хэтийн асуудлуудыг сонгогч түмэнд танилцуулах нь эдийн засгийн хувьд бодитой бус, улс төрийн хувьд зохисгүй, амлалт, хүлээлтэд хүргэх сөрөг үр дагавартай гэж үзэж байна.

Энэ хөтөлбөрийн үг үсэг, үзэл санааг сайтар анхааран судалваас өнгөрсөн 20 гаруй жилд улс төрийн намуудаас боловсруулж хэрэгжүүлж ирсэн бодлогоос зарчмын хувьд цоо шинэ хандлагатай, иргэн танаар овоглосон, иргэн таны төлөө, иргэн та өөрөө хэрэгжүүлэхэд нь оролцох гэсэн үзэл санаа, үг үсэг шингээстэй байгаа.

Энэ нь чухамдаа хүн төрөлхтний хөгжлийн өнөөдрийн сонголт болсон даацтай, оролцоотой, тэнцвэртэй хөгжлийн замын гол учир мөн.

**МОНГОЛЧУУД АА! ЭХ ОРОНДОО ЭЗЭН НЬ БОЛЖ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД
МОНГОЛДОО САЙХАН АМЬДАРЦГААЯ!**

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.27 № 489
таний -ны № -т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцоо бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Иргэний зориг ногоон намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд эвслийн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Иргэний зориг ногоон намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Иргэний зориг ногоон намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Иргэний зориг ногоон намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД